МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2017.11.27 № 3/3059

танай ____________-ны №____________-т

АЙМАГ, ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлаас 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал обьектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцож цагдаагийн алба хаасан хугацааг өсгөн нэмэгдүүлэхээр заасан.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2-т заасан хугацаа нь уг хууль хүчин төгөлдөр болохоос өмнө цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон гүйцэтгэх ажилтан, замын хөдөлгөөний зохицуулагчид хамаарахгүй байхаар зохицуулсан болно.

Иймд дээрх хуулийн дагуу цагдаагийн алба хаагчийн алба хаасан хугацааг дор дурдсан тодорхойлолтуудыг үндэслэн нэмэгдүүлэн тооцож цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоож олгох нь зүйтэй. Үүнд:

1.Цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар нэмэгдүүлэн тооцсон Цагдаагийн ерөнхий газрын тодорхойлолт;

2.Цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаас бусад офицерийн бүрэлдэхүүнд алба хаасан цагдаагийн алба хаагчийн алба хаасан 1 жилийг 1 жил 3 сараар нэмэгдүүлэн тооцсон Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтсийн тодорхойлолт;

3.Цагдаагийн алба хаагчийн ахлагчийн бүрэлдэхүүнд алба хаасан 1 жилийг 1 жил 3 сараар нэмэгдүүлэн тооцсон тухайн алба хаагчийн тэтгэвэр тогтоолгохын өмнө алба хааж байсан цагдаагийн газар, хэлтсийн тодорхойлолт зэрэг болно.

Дээр дурдсан цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албаны гүйцэтгэх ажилтан болон замын хөдөлгөөний зохицуулагчаас бусад цагдаагийн алба хаагчийн Цагдаагийн албаны тухай хуульд заасан хугацааг тооцохдоо Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн "Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2, Дотоодын цэргийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгүүдэд заасан ажлын байр

1003031

/албан тушаал/-ны жагсаалт"-ыг баримтлан цагдаагийн болон цэргийн алба хаасан хугацааг өсгөн нэмэгдүүлж тооцох хэрэгтэй.

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 01/644 тоот албан бичгийг хавсарган хүргүүлэв.

Хувийг Мэдээллийн технологийн төвд.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНЦЭЦЭГ

УХА0585
9081739 1116127241

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Самбуугийн гудамж 18, Утас: 7019-1087, Факс: 7019-1087,
Web: www.police.gov.mn, E-mail: info@police.gov.mn

2017.11.20 № 01/644

танай ____________-ны №____________-т

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Д.ЗОРИГТ
ТАНАА

Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2, Дотоодын цэргийн тухай хуулийн 36 зүйлийн 36.3 дахь хэсэгт хамрагдах ажлын байр /албан тушаал/-ын жагсаалтыг гаргаж хүргүүлэв.

Хавсралт 5 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА С.БААТАРЖАВ

0920708

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 86 ДУГААР
ЗҮЙЛИЙН 86.2 ДАХЬ ХЭСЭГТ ЗААСАН АЖЛЫН БАЙР
/АЛБАН ТУШААЛ/-НЫ ЖАГСААЛТ

| Д/д | Цагдаагийн албаны тухай хуулийн 86.2 | Ажлын байр /албан тушаал/ -ны нэр | Тайлбар /төсөвт, гэрээт/ |
|---|---|---|---|
| 1 | албадан эрүүлжүүлэх, саатуулах байр | Эрүүлжүүлэх, саатуулах байрны дарга эмч | Албадан эрүүлжүүлэх, эрүүлжүүлэх, баривчлах байрны дарга эмч |
| | | Эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч | Албадан эрүүлжүүлэх, эрүүлжүүлэх, баривчлах, саатуулах байрны эмч, их /бага/ эмч<br>Эрүүлжүүлэх саатуулах төвийн эмч |
| | | Эрүүлжүүлэх, саатуулах байрны жижүүрийн цагдаа | Албадан эрүүлжүүлэх, эрүүлжүүлэх, баривчлах, саатуулах байрны цагдаа, жижүүрийн цагдаа<br>Албадан саатуулах, баривчлах төвийн цагдаа |
| | | Эрүүлжүүлэх, саатуулах байрны цагдаа жолооч | Албадан эрүүлжүүлэх, эрүүлжүүлэх, баривчлах, саатуулах байрны цагдаа жолооч,<br>Жижүүрийн цагдаа жолооч,<br>Эргүүл, тусгай хамгаалалтын хэлтсийн цагдаа жолооч |
| 2 | улсын онц чухал обьектын хамгаалалт, харуул | Харуулын цагдаа | Харуулын цагдаа,<br>Харуулын ахлах цагдаа,<br>Харуулчин,<br>Монгол банкны цагдаа,<br>Банкны гэрээт цагдаа,<br>Билет, кассын цагдаа,<br>Вокзалын хэсгийн цагдаа,<br>Тээшний цагдаа,<br>Цагдаа /Улсын бүртгэлийн газрын гэрээт/<br>**Чингис Зочид буудлыг хамгаалах салаан цагдаа,**<br>**Усны эх булаг хамгаалах салаанд цагдаа**<br>**Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, тасагт цагдаа /2000 оноос өмнөх/** |
| | | Эргүүлийн офицер | Харуулын дарга,<br>Харуулын бага дарга,<br>Байцаагч салаан дарга,<br>Ахлах дэг журам сахиулагч,<br>Дэг журам сахиулагч |
| 3 | замын хөдөлгөөн зохицуулах | Хэлтэс, тасгийн дарга | Замын цагдаагийн алба, газрын дүүрэг дэх хэлтэс, орон нутаг дахь замын цагдаагийн тасаг, хэсгийн дарга |
| | | Чиглэлийн ахлах зохицуулагч | Замын цагдаагийн чиглэлийн ахлах байцаагч,<br>Замын цагдаагийн хэлтэс, тасгийн чиглэлийн ахлах байцаагч,<br>Чиглэлийн ахлах зохицуулагч |

| | | | |
|---|---|---|---|
| | | Ахлах зохицуулагч | Замын цагдаагийн ахлах байцаагч,<br>Замын цадаагийн алба, газар, хэлтэс, тасгийн ахлах байцаагч,<br>Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан ахлах зохицуулагч,<br>Ахлах зохицуулагч /Хамгаалалтын газрын Замын хөдөлгөөний зохицуулалтын хэсэг/ |
| | | Зохицуулагч | Замын цагдаагийн байцаагч, Замын цагдаагийн алба, газар, хэлтэс, тасгийн байцаагч, Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан зохицуулагч, Дүүргүүд дэх замын цагдаагийн тасгийн байцаагч, Шугам замын байцаагч, Техникийн шинжээч, хэргийн газрын үзлэгийн хэсгийн шинжээч, Техникийн ахлах байцаагч, байцаагч, Зохицуулагч /Хамгаалалтын газрын Замын хөдөлгөөний зохицуулалтын хэсэг/ |
| | | Цагдаа зохицуулагч | Замын цагдаа,<br>Зохицуулагч цагдаа,<br>Цагдаа зохицуулагч /Хамгаалалтын газрын Замын хөдөлгөөний зохицуулалтын хэсэг/ |
| 4 | эргүүл | Эргүүлийн офицер | Эргүүлийн ахлах офицер, офицер<br>Машинт эргүүлийн ахлах офицер, офицер хэв журмын ажилтан,<br>Хэв журмын ахлах ажилтан,<br>Хэв журмын ахлах байцаагч,<br>Бүлгийн дарга,<br>Хэв журмын офицер,<br>Бүлгийн ахлах офицер,<br>Бүлгийн офицер,<br>Хэсгийн төлөөлөгч,<br>Хэсгийн байцаагч,<br>Хамгаалалтын офицер |
| | | Эргүүлийн цагдаа | Эргүүлийн цагдаа,<br>Хэв журмын цагдаа,<br>Хамгаалалтын цагдаа,<br>Төмөр замын суудлын цагдаа,<br>Цагдаа /Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс, Эргүүл хамгаалалтын газар /801-р хороо/, Дипломат байгууллага, банк хамгаалах хэлтэс /шөнийн эргүүлийн 808-р анги/, 2005 он Дохиолол хамгаалатын алба/<br>**Салаан захирагчийн туслах**,<br>**Цагдан сэргийлэгч,**<br>**Сэргийлэгч,**<br>**Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, тасагт цагдаа /2000 оноос өмнөх/** |

| | | | |
|---|---|---|---|
| | | Эргүүлийн цагдаа жолооч | Машинт эргүүлийн цагдаа жолооч,<br>Хөдөлгөөнт эргүүлийн газрын цагдаа жолооч,<br>**Гэмт хэрэгтэй тэмцэх**, нийтийн хэв журам хамгаалах, **олон нийтийн аюулгүй байдлыг хангах** чиг үүрэг бүхий цагдаа жолооч,<br>**Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, тасагт цагдаа жолооч /2000 оноос өмнөх/** |
| 5 | жижүүрийн албанд | Ерөнхий жижүүр | Ерөнхий зохицуулагч,<br>Ерөнхий жижүүр |
| | | Жижүүрийн ахлах мөрдөгч | Жижүүрийн ахлах мөрдөгч, Чиглэлийн ахлах мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагч, **мөрдөн байцаагч**, хэрэг бүртгэгч, хэргийн газрын үзлэгийн мэргэшсэн шинжээч /Нийслэлийн цагдаагийн газрын Гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, мөн газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс, Мэдээллийн удирдлага, зохион байгуулалтын хэлтэс, Ахлах мөрдөн байцаагч /ЗЦА, ЗЦГ-ын Жижүүрийн шуурхай удирдлагын хэлтэс /Жижүүрийн мөрдөн байцаагч, Хэргийн газрын үзлэгийн чиглэлийн ахлах мөрдөн байцаагч, Кримналистикийн ахлах мэргэжилтэн, Шинжээч, Хэргийн газрын үзлэгийн мэргэшсэн шинжээч, Ахлах мөрдөгч /Нийслэлийн цагдаагийн газрын Шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс/<br>**Цэргийн төв эмнэлэг дэх хэрэг бүртгэгч** |
| | | Жижүүрийн ахлах офицер | Жижүүрийн ахлах офицер,<br>Хариуцлагатай зохицуулагч,<br>Зохицуулагч<br>Гэмтлийн эмнэлгийн ахлах хэрэг бүртгэгч,<br>Ахлах зохицуулагч,<br>Ахлах жижүүр,<br>Ёс журмын хэсгийн Хэв журмын ахлах зохицуулагч,<br>Ёс журмын ахлах зохицуулагч,<br>Хэв журмын жижүүрийн ахлах офицер,<br>Ёс журам сахиулах ажил хариуцсан ахлах байцаагч,<br>Цагдаагийн ерөнхий газрын төв байрны ахлах зохицуулагч,<br>Цагдаагийн ерөнхий газрын төв байр хариуцсан жижүүрийн ахлах офицер,<br>Цагдаагийн ерөнхий газрын төв байрны дотоод дэг журам хариуцсан офицер,<br>Хамгаалалтын ахлах офицер |

| | | | |
|---|---|---|---|
| | | Жижүүрийн офицер | Хяналт шалгалтын офицер, Шалгах механик /Автобааз/, Зохицуулагч-шалгах механик /Автобааз/,<br>Нийгмийн ажилтан, **Хүүхдийн байцаагч** /Нийслэлийн цагдаагийн газрын хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төв, тасаг/,<br>Мэдээлэл хүлээн авагч /Мэдээлэл, шуурхай удирдлагын төв/, Систем хариуцсан ээлжийн инженер, Мэдээллийн менежер, Мэдээллийн ахлах менежер,<br>Эргүүл, хяналт шалгалтын офицер,<br>Эргүүл, хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч, Бүлгийн зохицуулагч /Дотоодын цэргийн 809-р салбар, Хамгаалалтын газрын Шуурхай зориулалтын хэлтэс/,<br>Бүлгийн дарга /Тусгай ажиллагааны газар/Мэргэн буудагч/Тусгай ажиллагааны газар/Бүлгийн ахлах ажилтан/Тусгай ажиллагааны газар/Бүлгийн ажилтан/Тусгай ажиллагааны газар/Бүлгийн пиротехникч/Тусгай ажиллагааны газар/Бүлгийн ахлах офицер /Тусгай ажиллагааны газар/ |
| | | Жижүүрийн сэтгэл зүйч | Түр хамгаалах байрны сэтгэл зүйч,<br>Жижүүрийн сэтгэл зүйч |
| | | Жижүүрийн цагдаа | Жижүүрийн цагдаа,<br>Жижүүрийн цагдаа жолооч,<br>Конторын цагдаа,<br>Телекамерын жижүүрийн цагдаа,<br>Телекамерын хяналтын цагдаа<br>Дэг журам сахиулагч цагдаа,<br>Жижүүрийн туслах цагдаа,<br>Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрны цагдаа,<br>Журмын хашааны цагдаа,<br>Уулзалт, байцаалтын хэсгийн цагдаа,<br>Байцаалтын өрөөний цагдаа,<br>Жижүүрийн сувилагч,<br>Хянагч /Ганц худаг/,<br>Эрэлч нохойн албаны туслах төлөөлөгч,<br>Ээлжийн ахлагч,<br>Цагдаагийн ерөнхий газрын төв байрны жижүүрийн цагдаа,<br>Бүлгийн цагдаа /Тусгай ажиллагааны газар/,<br>3-р тусгай тасгийн цагдаа,<br>**Кабоны цагдаа** |
| | | Мэдээлэл хүлээн авагч жижүүрийн цагдаа | Мэдээлэл хүлээн авагч,<br>Мэдээлэл  хүлээн авагч цагдаа,<br>Мэдээлэл хүлээн авагч жижүүрийн цагдаа,<br>Дуудлага хүлээн авагч цагдаа<br>Оператор цагдаа /Замын цагдаагийн газрын Жижүүрийн хэлтэс/ |

--- ооо ---

ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 36 ДУГААР ЗҮЙЛИЙН
36.3 ДАХЬ ХЭСЭГТ ЗААСАН АЖЛЫН БАЙР
/АЛБАН ТУШААЛ/-ЫН ЖАГСААЛТ

| Д/д | Хуулийн заалтад хамаарах чиг үүрэг | Албан тушаалын ангилал | Ажлын байр /албан тушаал/ -ны нэршил |
|---|---|---|---|
| 1 | Улсын онц чухал объектын харуул, хамгаалалт | Ахлагч | -Харуулчин ахлагч,<br>-Эргүүлчин ахлагч,<br>-Жижүүрийн туслах,<br>-Жижүүрийн туслах цагдаа,<br>-Жижүүрийн жолооч,<br>-Жолооч,<br>-Оператор-харуулчин,<br>-ЦЕГ-ын төв байрны харуулчин,<br>-Хэв журмын цагдаа,<br>-Шалган нэвтрүүлэгч-харуулчин,<br>-Эргүүлчин,<br>-Довтлогч,<br>-Довтлогч-жолооч,<br>-Харуулын цагдаа<br>-Хамгаалалтын цагдаа<br>-Телекамерын хяналтын цагдаа,<br>-Цагдаа-жолооч,<br>- Бэлтгэл хүчний салбарын ахлагч<br>- Харуулчин |
| | | Офицер | -Харуул, хамгаалалтын салбарын захирагч,<br>-Тусгай салааны захирагч,<br>-Тусгай салааны орлогч,<br>-Харуулын дарга,<br>-Бүлгийн дарга,<br>-Эргүүлийн офицер,<br>-Ээлжийн зохицуулагч,<br>-Дэг журам сахиулагч,<br>-Эргүүл шалгалтын офицер,<br>-Шуурхай удирдлагын жижүүр,<br>-Шуурхай зохицуулагч,<br>-Жижүүрийн ахлах офицер,<br>-ЦЕГ-ын төв байрны дотоод дэг журам хариуцсан офицер,<br>-Хэв журмын байцаагч |

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР